



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот


Нийслэлийн Өмчийн харилцааны газрын данс бүртгэлээс хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу нэгдүгээр хавсралтад заасан 9 462 900 /есөн сая дөрвөн зуун жаран хоёр мянга есөн зуун / төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, хоёрдугаар хавсралтад заасан 1 467 470 /нэг сая дөрвөн зуун жаран долоон мянга дөрвөн зуун далан/ төгрөгийн эргэлтийн хөрөнгө, нийт 10 930 370 /арван сая есөн зуун гучин мянга гурван зуун далан/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 10 930 370 /арван сая есөн зуун гучин мянга гурван зуун далан/ төгрөгийн хөрөнгийг “Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөн зохицуулах төв”-д хүлээлгэн өгч, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /Х.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ОДНАСАН

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
 даргын 2019 оны 03-р сарын 27-ны өдрийн
 АРБ-р тушаалын хоёрдугаар хавсралт



ТТА №2371

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг данснаас хасах жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	ЭБХХХКомиссын шийдвэр
1	Диктофон их-560 өх	Ш	1	367,400.00	367,400.0	
2	Насос 380 у/ц	Ш	1	660,000.00	660,000.0	
3	Печь /шарф/	Ш	1	219,900.00	219,900.0	
4	Кофе бутлагч	Ш	1	99,000.00	99,900.0	
5	Хонх	Ш	1	11,000.00	11,000.0	
6	Цаас хэрчигч	Ш	1	109,270.00	109,270.0	
Нийт дүн					1,467,470.00	